

КРИМИНАЛИСТИКИЙН ТААМАГЛАЛЫГ ДЭВШҮҮЛЭХ БА ШАЛГАХ АЖИЛЛАГАА

PROFOUND ACTIVITY AND INSPECTION OF CRIMINALISTICS HYPOTHESIS



П.ЭРДЭНЭБААТАР

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх ажиллагааны онол, тактикийн тэнхимийн багш, цагдаагийн дэд хурандаа

ERDENEBAATAR P.

Police lieutenant colonel, Lecturer of the Faculty of Theory and Tactics of Investigation, Police Institute, Law Enforcement University

Товч агуулга: Криминалистикийн таамаглал нь бодит баримтад үндэслэсэн, гэмт үйл явдал болон түүний зарим байдлын мөн чанар, хэрэгт тогтоогдвол нотлох баримтын тухай мэдээллүүдийн хоорондын шалтгаант холбооны тухай төсөөлсөн тайлбар юм. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ихэнх үйл ажиллагаа нь таамаглал, таамаглалыг шалгах байдаг. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хэрэглэдэг таамаглал, түүнийг дэвшүүлэх болон шалгах танин мэдэхүйн аргуудын талаар тайлбарлахыг зорьсон болно.

Abstract: Criminal case hypothesis can be explained upon real life situations, criminal acts and their circumstances, possible criminal charges, and their connection to the crime. Criminal record, and criminal investigation also have the same hypothesis like the criminal case. An educated guess of what might have happened. In this article, we intended to find out about hypothesis and some logical methods of testing.

Түлхүүр үгс: Таамаглал-юмс, үзэгдлийн шалтгаан, мөн чанар, харилцаа холбоо, шинж байдлыг тайлбарлах зорилгоор дэвшүүлэн тавьж буй таамнал, төсөөлөл, санаа.

Key words: Hypothesis, statement, to falsify, deductive reasoning, inductive reasoning, investigation.

Криминалистик — гэдэг үг бол “кримини” гэдэг латин үгнээс гаралтай, монгол хэлэнд гэмт хэрэг гэсэн утгыг илэрхийлдэг. Криминалистик нь гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх аргын тухай шинжлэх ухаан юм.

Криминалистикийн таамаглал гэдэг бол гэмт хэргийн нөхцөл байдлуудыг урьдчилан багцаалсан тайлбарлал, өөрөөр хэлбэл үйлдэгдсэн гэмт хэргийн нотолбол зохих байдлууд, шалтгаан нөхцөлийн тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн урьдчилж багцаалсан зохих шалгалт, мэдээ баримтын үндэслэл юм.

Багцаалсан тайлбарлал (сэжиглэл)¹ гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн тухай тухайн байдлыг байгаа бүх зүйлүүдийн нь хамт дэс дараатай, нэг бүрчлэн нарийн задлан шинжилж, гүнзгий бодож, олон талаас нь сайн дүгнэсний үр дүнд гарах ёстой. Ийнхүү урьдчилж багцаалсан сэжиглэл нь гэмт үйлдэл мөн бишийн тухай, гэмт хэрэгтний тухай гэмт хэргийн нотлогдох байдлуудын тухай, түүний шалтаг, шалтгааны тухай, гэмт хэрэг үйлдсэн цаг, газар, багаж хэрэгслийн тухай асуудлаар дэвшигдэн гардаг.

¹ С.Жанцан. Хууль зүйн сэтгэл судлал. УБ., 2005. 162-163 дах тал



Сэжиглэлийг ийнхүү дэвшүүлэх нь гэмт хэргийн зөвхөн боломжтой байдлуудыг тайлбарлах төдийгүй гэмт хэрэгт холбоотой мэдээ баримтуудыг таних мэдэх арга болдог.

Гэмт хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаар шалгах нь үнэнийг мэдэж тогтоох явдал юм. Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаан дахь үнэнийг танин мэдэж тогтоох гэдэг бол мөн, биш гэсэн хоёр үнэнийг тогтоох явдал байдаг.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад үнэнийг мэдэж тогтоох нь диалектик материализмын ерөнхий хуулиудыг удирдлага болгоно.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед танин мэдэх явц нь хүний сэрлээс эхлэн ойлголт, задлах, нэгтгэх шинжилгээ хийж дүгнэлт гаргах хүртэлх хүний сэтгэхүйн процессод явагддаг үйл ажиллагаа. Иймд үнэнийг танин мэдэж тогтоох явдал хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед өөрийн онцлогоос тодорхой хязгаар, журамтай байдаг. Жишээлбэл: Үйлдэл, эс үйлдэл бүхнийг биш, зөвхөн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл өөрөөр хэлбэл зөвхөн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоодог. Тэгэхлээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн танин мэдэх зүйн хэрэгсэл нь (предмет) гэмт хэргийн бүрэлдэхүүн бөгөөд зорилго нь шүүн таслах ажиллагаанд хүрэлцээтэй үнэнийг танин мэдэж тогтоон өгөх явдал юм. Энэ танин мэдэх үйл ажиллагаа нь сэжиг дэвшүүлэхээс эхэлдэг. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн танин мэдэж үнэнийг тогтоох, ажиллагаа нь тодорхой онцлогтой нөхцөлүүдийг хангаж байж биелэгддэг үйл ажиллагаа юм. Үүнд:

1.Таних мэдэх хугацаа аль болох богино байж үр дүнд хүрдэг.

2.Хийх шинжилгээ нь өөрийн хүсэл зоригоор биш хууль зүйн дагуу, багаж хэрэгсэл болон арга тактиктэй явагдана.

3.Энэ танин мэдэх үйл явц нь зөвхөн эрх бүхий албан тушаалтан төрийн нэрийн өмнөөс явуулдаг ажил юм. (мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, шинжээч, шүүгч гэх мэт).

4.Заавал биелэгдэх шийдвэрийг гаргадаг.

5. Энэ танин мэдэхүйн процесс нь хийсвэр шинжилгээ болон оюун санааны дүгнэлтээр биш хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүний мэддэг мэдрэхүйн ойлголтоор явагдана.

Энэ ойлголт нь гэмт хэргийн нийгмийн хор аюул, шинж тэмдэг, шалтгаант холбоо, хэрэглэсэн багаж зэвсэг, гэмт хэрэг гарахад хүргэсэн нөхцөл шалтгаан, түүний субъектын хувийн чанар, зэргийн нийлбэрээс гарах ёстой гэтэл практик амьдралд сэжиглэл дэвшүүлэх болон шалгахад дээрх нөхцөлүүдийг хангалтгүй бүрдүүлэх, биелүлдэггүйгээс үндсэн хоёр алдаа гардаг байна. Үүнд:

1.Хэргийн газрын үзлэгийг мөрдөн байцаагч, прокурор, шинжээч, эрүүгийн төлөөлөгч нарын бүрэн бүрэлдэхүүнээр тус тусын үүргийг биелүүлж ажиллахгүйгээс болж сэжиглэлийг бүрэн гүйцэд, үнэн зөв дэвшүүлж чаддаггүй, эсвэл дэвшүүлсэн сэжиглэлийг гүйцэд цаг хугацаанд нь шалгаж чадахгүйгээс гэмт хэргийг илрүүлж чадахгүй байна.

2.Хавтаст хэргийн материал, шалгалтыг удирдаж байгаа цагдаагийн байгууллагын удирдах ажилтан, хяналт тавьж байгаа прокурорууд хэрэг материалыг өөрөө нэг бүрчлэн уншихгүй зөвхөн амаар танилцаж байгаа нь сэжиглэл бүрэн дэвшигдэж, зэрэгцэн шалгагдахгүй байх буюу мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь сэжиглэлийг муу дэвшүүлж байгаагаас хэргийг бүрэн илрүүлж чадахгүй илрүүлэлтийн хувь хангалтгүй байна.

Хавтаст хэргийн материалтай бүрэн танилцаж хянах нь ерөнхий болон хэсэгчилсэн сэжиглэл бүрэн олохоос гадна ажлын сэжиглэлийг зөв тогтоох нь ач холбогдолтой юм.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үнэнийг таних мэдэх ажиллагаа нь аливаа үзэгдэл юмсын мөн чанарыг судалж, шинжилж, бодит үнэнд хүрэхтэй тодорхой аргуудаар явагддаг. Үүнд:

1.Ажиглалт хийх

2.Тодорхойлон бичих

3.Нарийн хэмжих

4.Адилтгах

5.Туршин шалгах

6.Практикийг судлах зэрэг аргуудаар явагдана.

Эдгээр аргуудыг хэрэглэж ажилласны үр дүнд цугларсан нотлогдох боломжийн



тухай мэдээлэл, нотлох баримтын үндсэн дээр таамаглал дэвшүүлэх болон шалгадаг.

Сэжиглэл дэвшүүлж, шалгах гэдэг нь сэжиглэлээс бодит үнэнд шилжих дэвшил бөгөөд түүнийг шалгаснаар мэдэхгүй байснаас мэддэгт шилжиж буй танин мэдэхүйн явц юм болохоор сэжиглэлийн чанарыг мэдэх хэрэгтэй.

Сэжиглэлийн гол шинж чанар нь :

1.Үзэгдэл юмс, практикийн тухай урьдчилсан багцаалал нь заавал үндэслэлтэй байна.

2.Энэ үндэслэл нь ямар нэг гэмт хэрэгтэй шууд холбоотой байна.

3.Энэ үндэслэлийг зөвхөн эрх бүхий (мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, шүүгч, шинжээч) хүмүүсийн харьцаанд авч үздэг.

4.Энэ сэжиглэл нь зөвхөн үндэслэлтэй төдийгүй зайлшгүй зүйл байдагт оршино.

Сэжиглэл дэвшүүлэх болон шалгах явдал нь шинжлэх ухааны "гипотез"² "таамнал" -аас үүнийг болгон дэвшүүлэх арга барил, тактик, шинжлэх багаж хэрэгсэл, хугацаа шалгах ажиллагаагаараа ялгаатай юм.

Гэвч сэжиглэл дэвшүүлнэ гэдэг бол гипотезын нэг төрөл юм. Шинжлэх ухааны гипотез нь үзэгдэл фактын зүй тогтоолыг тогтоохын тулд дэвшигддэг юм.

Гэтэл сэжиглэл зөвхөн гэмт хэрэгт холбоотой хэсэгхэн хязгаартай фактуудын хүрээнд хийх шинжилгээтэй холбоотой юм.

Сэжиглэл нь эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарчим, журмаар хэргийн байдал, ямар үйлдэл үйлдэгдсэн, хэн үйлдсэн, түүний шалтаг шалтгаан, үйлдсэн газар, цаг, арга, зэвсгүүдийн шинж чанарыг тайлбарлахын тулд дэвшигдэж шалгагддаг бол шинжлэх ухааны гипотезийг дэвшүүлэн шалгах нь тусгай шинжлэх ухааны багаж хэрэгсэл, арга барилаар шууд ажиглах, туршилт хийх зэргээр явагдана. Сэжиглэл бол өөрийн агуулга шинж чанараараа хэд хэдэн төрөл байдаг.

Сэжиглэл дэвшүүлэх объектоор нь:

1.Ерөнхий сэжиглэл нь гэмт хэргийн бүхий л байдал, шинж чанарыг ерөнхийд нь судлах ба илрүүлэх

үндэслэлийг харуулсан болон биш 3-4 сэжиглэлийг хэлдэг.

2.Хэсэгчилсэн сэжиглэл нь нэг фактаас үндэслэж хийсэн багцаалсан тайлбарлал юм.

Энэ нь гэмт хэргийн байдлыг бүхэлд нь тодорхойлж чадахгүй бусад олон фактуудаас үндэслэж урьдчилсан багцаалууд гаргадаг. Үүнийг хэсэгчилсэн верс гэж нэрлэдэг.

Өөрөөр хэлбэл гэмт хэргийн бүх байдлаар биш зөвхөн хэсэгхэн байдал нь урьдчилсан багцаалалыг дэвшүүлэхийг хэлнэ. Жишээлбэл: Гэмт хэргийн цаг үеийн тухай, газар, багаж зэвсгийн тухай гэх мэт. Энэ хоёр төрлийн верс нь эрүүгийн шинж чанартай байдаг.

3.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажлын сэжиглэл гэж бас хуваана.

Энэ бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагааг давуутай байдлаар зохион байгуулах шинж чанартай байна. Гэмт хэргийн зэвсэг, нотлох баримт оршиж буйг мэдсэн боловч түүнийг хаана нуусан, яаж олж авах тухайг урьдчилан багцаалах явдлууд юм.

Сэжиглэлийг дэвшүүлэх субъектээр нь:

а)Мөрдөн байцаалтын сэжиг (Энэ нь ерөнхий болон хэсэгчилсэн сэжиг байна).

б)Эрэн сурвалжлах ажиллагааны сэжиг / Энэ хэсэгчилсэн сэжиг байна/.

с)Шинжээчийн сэжиг (Зөв ба эсрэг сэжиг байна).

д)Шүүгчийн сэжиг (Энэ нь зөв ба эсрэг сэжиг байна) гэсэн төрлүүдтэй байдаг.

Сэжиглэлийг дэвшүүлэх гэдэг нь тухайн гэмт хэрэг болон фактад задлан шинжилгээг хүний сэтгэхүйн үйл ажиллагаагаар хийж буй явц болохоор нотлох баримт буюу түүний объектын нотлогдох боломжийн тухай мэдээллүүдээс үндэслэж тэдний хооронд ямар харилцаа холбоо байгааг сэтгэхгүйгээр танин мэдэх явдал юм.

Тэдгээр нотлох баримт, түүний объектын нотлогдох боломжууд нь хоорондоо заавал холбоотой байж сэжиг дэвшигддэг.

Энэ холбоо нь зайлшгүй холбоо. Жишээлбэл: (Шалтгаант холбоо) тохирох төстэй холбоо гэж байдаг. Жишээлбэл: Түр зуурын холбоо, өргөн

² Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос монгол толь. УБ., 1982.



дэлгэр тархмал байдаг холбоонуудыг хэлдэг.

Сэжиглэлийг шалгах ажиллагаа бол мөрдөн байцаалтын ажиллагаа болон эрэн сурвалжлах, шинжээч, шүүгчийн арга ажиллагаагаар явагдана. Энэ шалгалтын үед хоёр үндсэн аюултай алдаа тохиолдож болдог. Жишээлбэл:

1. Ямар нэгэн сэжиглэлийг хэтрүүлэн үнэлэх буюу зарим сэжиглэлийг олж харж чадахгүй орхигдуулах аюултай байдаг.

2. Ямар нэг үндэслэлгүй буруугаар сэжиг дэвшүүлэх явдлууд юм.

Сэжиг бол шууд ба шууд бус нотлох баримтуудаас үндэслэгдэнэ.

Шууд нотлох баримт бол нэг л үнэн сэжгийг гаргана. Шууд бус нь олон сэжгийг гаргадаг.

Ийнхүү сэжиглэлийг дэвшүүлэх нь тодорхой үндэслэл дээр өмнөө тавьсан зорилготой байдаг. Жишээлбэл: Шинжээч томилсноор түүний үр дүнгээс, хэргийн газрын үзлэгээр олсон эд мөрийн баримтуудаар, гэрч хохирогч, сэжигтний мэдүүлгүүдээс үндэслэн сэжиглэлийг дэвшүүлнэ.

Сэжиглэлийн зорилго нь нотлох баримтын үнэнийг тогтоох явдал байдаг. Энэ нь нотлох баримт болохоос гадна гэм буруугийн үйлдэл ба эс үйлдлийг нотолж байгааг л тогтоох явдал юм.

Криминалистикийн версийг зөв дэвшүүлж сайн шалгах явдлын ач холбогдол доорх байдлаар илэрдэг байна.

1. Мөрдөн байцаалт болон гүйцэтгэх ажлын чиглэлийг тодорхой болгож өгнө.

2. Шинээр үйлдэгдэх гэмт хэргийг урьдчилан сэргийлж, таслан зогсоох ажлыг зохион байгуулахад тусалдаг.

3. Мөрдөн байцаалт болон гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний үндэслэл нь болдог.

4. Нотлох баримт болон түүний нотлогдох боломжийн үндэслэл болох

төдийгүй түүнийг баримтжуулах эх үүсвэр нь болно.

5. Гарсан хэргийн нөхцөл шалтгааныг илрүүлж тайлбарлах нөхцлийг бүрдүүлж өгнө.

6. Шинжээчийн шинжилгээний ажлын чиглэлийг тодорхойлж өгнө.

7. Мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтан, шинжээч нарын хамтран ажиллах ажлын үндсийг тавьж өгдөг.

ДҮГНЭЛТ

Сэжиглэлийг дэвшүүлж түүнийг шалгах ажиллагаа нь мөрдөн байцаалт болон эрэн сурвалжлах үйл ажиллагааны ажлыг төлөвлөж явуулах нэг хэсэг болдог. Сэжиглэлийг шалгах ажиллагаа бол тодорхой төлөвлөгөөтэй нарийн журам, зарчимтай явагдах ёстой. Практик амьдралаас үзэхэд үндсэн 4 журмыг нарийн ханган биелүүлэх ёстой.

САНАЛ

а) Бүх дэвшигдсэн сэжиглэлийг бүрэн шалгаж байх.

б) Бүх сэжиглэлийг паралель зэрэгцүүлэн шалгах. Ээлж дугаараар байж болохгүй юм.

в) Нотолгооны фактыг тогтоох замаар шалгалт явуулж байх.

г) Мөрдөн байцаалт, эрэн сурвалжлалтын үйл ажиллагааг бодиттойгоор бүх талаас нь шалгаж ажиллах гэсэн шалгуурыг баримтлан ажиллах шаардлага тулгардаг.

Эдгээр журам зөрчигдвөл гэмт хэрэг илрэх явдалд саад болдог. Тухайлбал: хүн амины гэмт хэрэгт сэжиглэлийг хэтрүүлэн шалгаснаар гэм буруугүй хүнд хилсээр ял шийтгэл оногдуулах үндэс болохыг үгүйсгэх аргагүй юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

1. Ж.Хурцгэрэл. Криминалистик. УБ., 2002.

2. С.Жанцан. Хууль зүйн сэтгэл судлал. УБ., 2005.

3. Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос монгол толь. УБ., 1982.

Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор,
цагдаагийн хурандаа М.Эрдэнэбаяр